



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/05

Мандалговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.4, 27.3 дах заалт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :


Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт /Мандал сургуулийн урд талд/ байршилтай "Тааны амт" ХХК /РД:3428818/-ын түрээсийн орон сууцны зориулалттай 5851 м² /0,5га/ газраас "ЭОЖИН" ХХК /3430553/-д 2900 м²/0,2га/ газрыг түрээсийн орон сууц, үйлчилгээний зориулалтаар шилжүүлж, үлдсэн 2950 м² /0,29га/ газрыг "Тааны амт" ХХК /3428818/-д 500м² /0,05 га/, 2450м² /0,24га/-аар тус тус түрээсийн орон сууц, үйлчилгээний зориулалтаар 14 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх аж ахуй нэгжүүдтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч /Р.Мөнхтогтох/, аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/517 тоот захирамжийн "Тааны амт" ХХК-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000310168 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



820000240